



БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН  
ТУШААЛ

2016 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Барилгын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалт, Яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 4/2016 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм" /БД 81-106-16/-ийг 1 дүгээр, "Барилга, байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ"-г 2 дугаар, "Гадна зам талбай, бусад жижиг барилга, тохижилтын ажлын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ"-г 3 дугаар, "Гадна инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ"-г 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан жишиг үнэлгээ, хэрэглэх дүрмийг хэвлэн олшруулж, нийтэд түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ /Ц.Амарсанаа/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 29 дүгээр тушаалаар баталсан "Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ хэрэглэх дүрэм" /БД 81-106-11/-ийг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  МӨНХБАЯР



08 00668

Барилга, хот байгуулалтын сайдын  
2016 оны 2 дугаар сарын 28 ны өдрийн  
203 дугаар тушаалын 1-р хэвсэгт



## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭГ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

### Нэг. Ерөнхий зүйл.

1. "Барилгын тухай хууль"-ийн 33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалтыг хэрэгжүүлж, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны ...- тушаалаар баталсан барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү дүрмийг мөрдөнө.

2. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг зураг төслийн өмнөх шатанд барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний төсөвт өртгийг урьдчилан тодорхойлох, хөрөнгө оруулалтын хөтөлбөр зохиох, эдийн засгийн тооцоо, судалгаа, шинжилгээ хийх, зардлын аргаар тооцсон хөрөнгийн үнэлгээнд харьцуулалт хийх, нийгэм, эдийн засгийн хөтөлбөрүүдийн тооцоо, судалгаа хийж хөрөнгө оруулалтыг урьдчилан төлөвлөх, зураг төсөл зохиогчдод оновчтой шийдэл гаргахад баримжаа болгох зэрэгт хэрэглэнэ. Түүнчлэн хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагыг барилга байгууламжийн өртөг тодорхойлох ижил нөхцөл, мэдээлэлээр хангах зэрэгт хэрэглэх зориулалттай болно.

3. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг өртгийн хандлагаар хөрөнгийн үнэлгээ хийхэд тооцооны суурь материал болгох, мөн барилга байгууламжийн үнэлгээний өртгийн хандлагын тооцоо, санхүүгийн тайлагнал, татаарын зориулалтын үнэлгээнд баримжаа болгон жишиг байдлаар хэрэглэж болно.

4. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг санхүүжилтэд хэрэглэхгүй.

5. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг тооцохдоо төлөөлөл болгон сонгож авсан барилгын магадлал хийгдсэн, ажлын зураг төслийг үндэслэн уг барилгын төсөвт өртгийг зохиож, ажлын зургийн тэнхлэгээр нь барилгын нийт талбайг тооцсоны үндсэн дээр нэгж талбайд ногдох дундаж төсөвт өртгийг тодорхойлсон.

### Хоёр. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээний тооцооны үндэслэл

6. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тогтооходоо Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм"/БНБД81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм"/ БНБД 81-95-12/-ын дагуу төсөв зохиож, төсвийн тооцоонд Дэд бүтцийн сайдын 2004 оны 177 дугаар тушаалаар баталсан "Цахилгаан, холбоо, автоматжуулалтын ажлын төсвийн суурь норм", Барилга, хот байгуулалтын сайдын

2006 оны 142, 2005 оны 21, 2008 оны 55 дугаар тушаал, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга, сантехникийн ажлын төсвийн суурь норм", түүний нэмэлт, өөрчлөлтүүдийг тус тус баримталсан.

7. Төсвийн материалын тооцоонд "2015 оны материал, хийц эдлэлийн үнийн лаалах", цалингийн тооцоонд Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 263 дугаар тушаалаар баталсан барилгын ажилчдын тарифт цалингийн жишиг, машин механизмын тооцоонд Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 18-р тушаалаар баталсан машин цагийн үнэ, тээврийн тооцоонд барилга болон авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан 1 тонн километрийн жишиг тарифыг тус тус хэрэглэсэн.

8. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцохдоо Улаанбаатар хотыг жишиг болгож, газар хөдлөлтийг 7 баллаар авч, 2015 оны жилийн эцсийн байдлаарх барилгын материал, хийц эдлэлийн үнэ болон мэдээллийн хэрэгсэлээр зарлагдсан үнийг жишиг болгон хэрэглэсэн.

9. Барилгын гүйцэтгэгч байгууллагын төсөвт ашиг, барилгын ажил гүйцэтгэх ерөнхий нөхцлийг бүрдүүлэх зардлыг тооцохдоо "Барилгын төсөв зохиох дүрэм"-д заасан норм, хувь хэмжээг баримтлан дүрмийн дагуу тооцсон. Мөн захиалагчийн хангалтын зардал /зөвлөх үйлчилгээ/, нормчлолын сангийн шимтгэл, даатгал, магадлашгүй ажлын зардал, нэмэгдсэн өртгийн албан татварыг тооцсон.

10. Сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгөөр баригдаагүй, шинэчилсэн зураг төсөөгүй зарим барилгуудын нэгж үнийг тооцохдоо судалгаа тооцооны арга болон хөрөнгийн үнэлгээнд олон улсад мөрддөг, үнийн жилийн дундаж өсөлтийг өнөөгийн үнэнд шилжүүлэх аргаар тооцсон.

11. Зам талбай, мод, саравч зэрэг жижиг байгууламжийн нэгж талбайн төсөвт өртгийг тодорхойлохдоо Сангийн сайдын 2009 оны 135-р тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал"-ын хавсралтаар баталсан барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ болон түүнээс хойшхи 2015 он хүртэл хугацааны барилга угсралтын ажлын үнийн индексээр тооцож оруулсан.

#### **Гурав. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх**

12. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэн барилга байгууламжийн төсөвт өртгийг урьдчилан тооцохдоо төлөвлөж байгаа барилга байгууламжийн нийт талбай, инженерийн шугам сүлжээний нийт уртын хэмжээг тодорхойлж, түүнийг тухайн барилга байгууламжийн нэр төрөлд тохирох нэгж талбайн төсөвт өртөг, нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээгээр үржүүлнэ.

13. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ батлагдснаас хойшхи хугацаанд тооцогдсон "Барилга угсралтын ажлын үнийн индекс"-ийг хэрэглэж дараа жилүүдэд баригдах барилга байгууламжийн төсөвт өртгийг тооцно. "Барилга угсралтын ажлын үнийн индекс"-ийг санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан индексээр тооцно.

14. Тээврийн зардлыг тооцохдоо тухайн баригдах барилга байгууламж нь Улаанбаатар хот, аймгийн төв, хилийн боомтоос алслагдсан зайн хэмжээ /км-ээр/ харгалзан барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээнд Хүснэгт №1-д заасан илтгэлцүүрийг хэрэглэнэ.

Хүснэгт №1

| №  | Улаанбаатар хот, аймгийн төв, хилийн боомтоос алслагдсан зайн хэмжээ /км-ээр/ | Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээнд хэрэглэх тээврийн зардлын илтгэлцүүр |
|----|---|--|
| 1. | 50-500 хүртэл   | 1,05   |
| 2. | 500-1000 хүртэл   | 1,12   |
| 3. | 1000-с дээш   | 1,15   |

15. Улаанбаатар хотоос өөр газар төлөвлөгдөж байгаа барилга байгууламжийн урьдчилсан төсөвт өртгийн хэмжээг тодорхойлохдоо БХБ-ын сайдын 2016 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 85 дугаар тушаалаар баталсан байгалийн зарим хүчин зүйлсийн нөлөөллийн итгэлцүүр хэрэглэнэ.

16. Стандартчлал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал" MNS6058:2009 стандартын дагуу тооцсон сууцны талбайн хэмжээг үндэслэн тухайн орон сууцны төсөвт өртгийг тодорхойлохдоо барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээнд 1,10 гэсэн илтгэлцүүр хэрэглэнэ.

17. Барилгын хана, суурь, хучилтын хийцийг доорхи ангиллаар тооцлоо.

Хүснэгт №2

| Үнийн ангилал | Даацын хийц, бүтээц  | Хана   | Хучилт   |
|---------------|--|--|--|
| A             | Төмөр бетон арагт бүтээц   | Тоосго, блокон дүүргэгчтэй   | Цутгамал бетон хучилт  |
| B             | Угсармал төмөр бетон   | Угсармал төмөр бетон   | Угсармал төмөр бетон   |
| C             | Холимог (бетон бус, зүрхэвчтэй)  | Даацын тоосго, блокон дүүргэгчтэй  | Угсармал, цутгамал   |
| D             | Даацын өрөгт болон модон холимог бүтээцтэй   | Холимог дүүргэгч болон модон   | Модон болон хөнгөвчилсэн хавтан  |
| S             | Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сэндвич/ болон хөнгөвчилсэн бүтээцтэй | Мод болон хөнгөвчилсэн хавтан, Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сэндвич/ | Модон болон хөнгөвчилсэн Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сэндвич/ |

18. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг төслийн тооцоонд хэрэглэх бол элэгдэл тооцохын өмнөх бүрэн сэргээн босгох /орлуулах/ өртөг дээр тоног төхөөрөмжийн үнэ, түүний угсралт, зураг төсөл, хайгуул, бусад хөрөнгө оруулалтын зардлыг нэмж тооцно.

19. Барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээний тооцоог төвлөрсөн инженерийн хангамжтай барилгад хийсэн тул ердийн пийшин халаалттай болон нам даралтын зуухнаас халдаг барилгуудад Хүснэгт №3-д заасан илтгэлцүүрийг хэрэглэнэ.

#### Хүснэгт № 3

| № | Барилгын төвлөрсөн бус халаалтын төрөл             | Илтгэлцүүр |
|---|--|------------|
| 1 | Ердийн пийшин халаалттай барилга                   | 0.75       |
| 2 | Нам даралтын зуухнаас халаахаар төлөвлөсөн барилга | 0.95       |

20. Барилгын гадна ханын гадна гадаргуу хоорондын зайг үндэслэн барилгын нийт талбайг тодорхойлсон үед Барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг Хүснэгт №4-д заасан илтгэлцүүрээр бууруулна.

#### Хүснэгт №4

| № | Гадна ханын зузаан   | Илтгэлцүүр |
|---|----------------------|------------|
| 1 | 510 мм-ийн зузаантай | 0.94       |
| 2 | 640 мм-ийн зузаантай | 0.92       |

21. "Барилгын тухай хууль"-ийн 40.1.24; 10.1.1-д заасан зөвшөөрөл шаардахгүй ангилалд багтах, хот аймгийн төвийн гэр хороолол, зуслан, сум бригадад аж ахуйн аргаар баригдах барилгуудын өртгийг шууд зардлаар нь тооцох буюу Барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг 0.70-0.75 гэсэн илтгэлцүүрээр бууруулж тооцож болно.

22. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 182-р тушаалаар батлагдсан "Зураг төслийн ажлын жишиг үнэ"/БД 81-16-12/-ийн 3.2.4-д заасны дагуу барилгын өндрийг орон сууцны барилгад 3.3м, үйлдвэрийн барилгад 4.5м, үйлчилгээний барилгад 3.6м хүртэл байхаар барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон. Хэрвээ барилгын өндөр дээрх хэмжээнээс их бол нэмэгдсэн 1м дутамд нь 5%-иар жишиг үнэлгээг өсгөнө. Харин барилгын өндөр дээрхээс бага байвал жишиг үнэлгээг бууруулах тохируулга хийхгүй.

23. Барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээнд илтгэлцүүр хэрэглэх жишээг үзүүлье.

Төв аймгийн Бүрэн суманд нам даралтын зуухаар халаах, төмөр бетон аргат бүтээцтэй, блокон ханатай, цутгамал бетон хүчилттай, 2000 м<sup>2</sup> талбайтай сургуулийн барилгыг 2016 онд барихаар төлөвлөж байгаа бол олон нийтийн барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ тогтоосон хүснэгтээс "Сургууль" гэсэн нэр төрлийг сонгон харахад 1м<sup>2</sup> талбайн жишиг үнэлгээ 925.92 мянган төгрөг байна.

| д/д | Объектын нэр       | Барилгын талбай /м2/ | Нэгж талбайн төсөвт өртөг /мян.төг/ | Байгалийн нөлөөллийн илтгэлцүүр | Тээврийн зайн илтгэлцүүр | Нам даралтын зуухнаас халаах барилгын илтгэлцүүр | Барилга угсралтын ажлын 2016 оны үнийн өсөлтийн индекс | Нийт төсөвт өртөг /мян.төг/ / 2*3*4*5*6*7 / = 8 |
|-----|--------------------|----------------------|-------------------------------------|---------------------------------|--------------------------|--|--|---|
| 0   | 1                  | 2                    | 3                                   | 4                               | 5                        | 6  | 7  | 8   |
| 1   | Сургуулийн барилга | 2000м2               | <b>925.92</b>                       | 1,10                            | 1,05                     | 0,95   | <b>1,02</b>  | <b>2072570069</b>                               |

Үүнд : Нэгж талбайн жишиг үнэлгээгээр тооцсноор Сургуулийн барилгын төсөвт өртөг 2000м2 \* 925.92 мянган төгрөг =1851840,0 мянган төгрөг

Тээврийн зайн илтгэлцүүрийг энэ дүрмийн 11-р зүйлд зааснаар авбал энэ барилга нь Улаанбаатар хотоос 500 хүртэл км зайн тойрогт багтаж байгаа тул 1,05

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн илтгэлцүүрийг БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалаар батлагдсан "Жишиг үнэлгээний аргачлал"-ын 1 дүгээр хавсралтын дагуу III зэрэглэл K=1.10

Нам даралтын зуухнаас халаахаар төлөвлөсөн барилгын илтгэлцүүр - 0,95

2016 оны "Барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн индекс"-1,02 гэж үзвэл

Энэ сургуулийн барилгын төсөвт өртөг нь:

$2000\text{м}^2 * 925,92 * 1,10 * 1,05 * 0,95 * 1,02 = 2072570,07$  мянган төгрөг болно

Барилгын өндөр нормативт хэмжээнд байгаа тул үнийн өсөлт хийхгүй.

24. Энэхүү үнэлгээгээр тооцсон нийт өртгийг төсөв, төлөвлөгөө, төсөлд хэрэглэх бол олон улсад мөрддөг өнөөдрийн үнийг ирээдүйн үнэнд шилжүүлдэг арга зүйн томъёоллоор тооцож хэрэглэнэ. Хөрөнгийн үнэлгээнд хэрэглэх бол элэгдлийн нормоор тооцсон хуримтлагдсан элэгдлийг хасч өнөөгийн үлдэгдэл үнийг тооцох журмаар хэрэглэнэ.

Уг жишиг үнийг ирээдүйд баригдах барилгын өртгийг тооцоходоо өнөөгийн үнийг ирээдүйн үнэнд шилжүүлдэг мөнгөний үнэ цэнийг дараах томъёогоор тодорхойлно.

$$FV = PV * (1 + i)^n$$

FV - Ирээдүйн төлөвлөгөөт оны үнэ

PV- Суурь үнэ ( батлагдсан жишиг үнэлгээгээр тооцсон)

i- Барилга угсралтын ажлын үнийн сүүлийн 3-5 жилийн дундаж цэвэр өсөлт

n- Ирээдүйн үнийн өсөлт тооцсон жилийн тоо

Ирээдүйд баригдах барилгын төсөвт өртгийг тооцох жишээг үзүүлье. Дээрхи сургуулийн барилгыг 2018 онд баригдана гэж үзвэл:

$PV = 2072570,07$  мянган төгрөг (нэгж хүчин чадлын үнэлгээгээр тооцсон өнөөгийн  $1\text{м}^2$ -ийн үнэ)

Уг барилгыг 2018 онд баригдана гэж үзсэн учир  $n = 3$  жил болно

Барилга угсралтын ажлын үнийн индексийн өсөлт

$$i_1 = \frac{2014}{2013} = 1.03, \quad i_2 = \frac{2015}{2014} = 0.99, \quad i_3 = \frac{2016}{2015} = 1.02$$

гэж үзвэл жилийн дундаж өсөлт нь  $(1,03+0,99+1,02) : 3 = 1,0133$  буюу жилийн дундаж цэвэр өсөлт нь  $1,0133-1,0 = 0,0133$  болно.

$$FV = 2072570,07 \cdot (1+0,0133)^3 = 2\,156\,509,16 \text{ мянган төгрөг болж байна.}$$

#### **Дөрөв. Бусад**

25. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тодорхойлсон тооцоонд барилга байгууламжийг барих газар чөлөөлөхтэй холбогдсон зардал, инженерийн шугам сүлжээ зөөж, шилжүүлэх болон үйлдвэрийн барилгын технологийн тоног төхөөрөмжийн үнэ өртөг, түүнчлэн газрын үнэ, борлуулалтын ашиг тусгагдаагүй болно.

26. Барилгын нэгж талбайн жишиг үнэлгээний тооцоонд гадна инженерийн шугам сүлжээний ажлын өртөг болон тусгайлан баригдсан туслах барилгууд, дэд өртөө, цооног, уурын зуухны барилгуудыг оруулаагүй тул тэдгээрийг тусад нь үнэлнэ.

27. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон барилга байгууламжаас хийц бүтээц болон инженерийн системийн шийдлийн ялгаатай объектын хувьд тусгай тооцоогоор нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тогтооно. Мөн барилга байгууламжийн үндсэн материал технологи нь барилгын салбарт шинээр нэвтэрч байгаа болон тодорхой цөөн тоогоор баригдах объектын хувьд нэгж хүчин чадлын төсөвт өртгийг тусгайлан тогтооно.

28. 110кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станц, дулааны станц, уул уурхайн барилга байгууламж барих нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээг хэрэглэхэд энэ дүрэм хамаарахгүй.

Барилга, хот байгуулалтын сайдын  
2016 оны 62 дугаар сэлэнгэ 8-ны өдрийн  
203 дугаар тушаалын 2-р хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ**

| Д.<br>А                   | Барилга<br>байгууламжийн нэр<br>төрөл                 | Хүчин<br>чадлын<br>хэмжих<br>нэгж | Нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ /мян. төг/<br>Барилга байгууламжийн хийц бүтээцийн<br>ангилал |         |         |         |        |
|---------------------------|---|-----------------------------------|---|---------|---------|---------|--------|
|                           |   |                                   | A   | B       | C       | D       | S      |
|                           |   |                                   | Нэг. Олон нийтийн барилга   |         |         |         |        |
| 1                         | Захиргаа, аж ахуй,<br>албан контор /шилэн<br>фасадтай | 1 м.кв                            | 1265.55<br>1400.56  | 1073.35 | 885.48  | 870.16  | 750.66 |
| 2                         | Соблын төв /шилэн<br>фасадтай                         | 1 м.кв                            | 1245.22<br>1506.8   | 1339.50 | 1122.07 | 882.27  |        |
| 3                         | Театр   | 1 м.кв                            | 1160.68   |         | 1176.32 |         |        |
| 4                         | Спорт заал  | 1 м.кв                            | 1104.44   | 1043.00 | 985.60  | 810.60  | 781.61 |
| 5                         | Худалдаа үйлчилгээ,<br>битүү зах                      | 1 м.кв                            | 1155.0  | 1268.39 | 1100.0  | 1160.0  | 737.43 |
| 6                         | Нийтийн хоол,<br>зоогийн газар                        | 1 м.кв                            | 1166.55   |         | 1100.0  | 956.40  | 870.30 |
| 7                         | Ахуй үйлчилгээний<br>төв /шилэн фасадтай              | 1 м.кв                            | 1228.4<br>1480.1  |         | 1050.0  | 848.21  | 850.30 |
| 8                         | Сургууль  | 1 м.кв                            | 925.92  | 1342.26 | 608.58  | 997.44  |        |
| 9                         | Цэцэрлэг ясли   | 1 м.кв                            | 1185.74   | 1086.37 | 1089.12 | 1173.33 |        |
| 10                        | Дотуур байр   | 1 м.кв                            | 981.06  | 1084.12 | 1007.17 | 981.56  |        |
| 11                        | Клиник  | 1 м.кв                            | 1046.89   | 1244.28 | 1170.12 | 1030.0  |        |
| 12                        | Эрүүл мэндийн төв                                     | 1 м.кв                            | 1015.06   |         | 1075.06 | 1019.9  |        |
| 13                        | Өрхийн эмнэлэг,<br>цагдаа, хорооны<br>цогцолбор       | 1 м.кв                            | 815.52  | 840.45  | 815.52  | 790.66  |        |
| 14                        | Усан бассейн  | 1 м.кв                            | 1554.01   |         | 1380.18 |         |        |
| 15                        | Банк санхүү / шилэн<br>фасадтай                       | 1 м.кв                            | 1215.5<br>1389.6  |         | 1227.66 | 810.06  |        |
| 16                        | Зочид буудал  | 1 м.кв                            | 1250.66   |         | 1176.00 | 980.00  |        |
| Хоёр. Орон сууцны барилга |   |                                   |   |         |         |         |        |
| 1                         | Амины орон сууц                                       | 1 м.кв                            | 1551.55   |         | 1342.28 | 1290.6  |        |
| 2                         | Нийтийн орон сууц                                     | 1 м.кв                            | 1120.65   | 1035.0  | 922.31  |         |        |

|  |   |        |         |         |         |         |        |
|--|---|--------|---------|---------|---------|---------|--------|
| 3  | Бүрэн цутгамал                          | 1м.кв  | 1456.83 |         |         |         |        |
| Гурав.Үйлдвэрийн барилга                 |   |        |         |         |         |         |        |
| 1  | Засвар механикийн үйлдвэр               | 1 м.кв | 960.56  | 893.08  | 776.59  |         | 780.0  |
| 2  | Авто машины гараж                       | 1 м.кв |         | 778.86  | 677.27  | 575.68  | 650.0  |
| 3  | Хүнд машин механизмийн гараж            | 1 м.кв |         | 1037.70 | 902.35  |         | 1412.3 |
| 4  | Хөнгөн үйлдвэр (үндсэн цех)             | 1 м.кв | 1150.16 | 952.61  | 828.36  |         |        |
| 5  | Хэвлэх үйлдвэр (үндсэн цех)             | 1 м.кв | 1290.16 | 1050.03 | 913.07  |         |        |
| 6  | Хүнсний үйлдвэр (үндсэн цех)            | 1 м.кв | 1380.00 | 1126.86 | 1260.00 |         |        |
| 7  | Барилгын материалын үйлдвэр             | 1 м.кв | 1100.20 | 1056.10 | 1198.82 |         |        |
| 8  | Арьс нэхий, ноосны үйлдвэр (Үндсэн цех) | 1 м.кв | 1060.0  | 909.93  | 791.24  |         |        |
| 9  | Тоосгон завод (Үндсэн цех)              | 1 м.кв | 1119.33 | 1070.16 | 973.33  |         |        |
| 10                                       | Шохойн үйлдвэр                          | 1 тн   |         |         | 76.79   |         |        |
|  |   | 1 м.кв |         |         | 1076.50 | 915.03  | 830.00 |
| 11                                       | Төмөрлөгийн үйлдвэр (Үндсэн цех)        | 1 м.кв | 1572.79 | 1480.72 | 1367.64 |         |        |
| 12                                       | Бетон эдлэлийн цех (Үндсэн цех)         | 1 м.кв |         | 1253.41 | 1089.92 |         | 880.00 |
|  |   | 1м.куб |         |         | 1413.49 |         |        |
| 13                                       | Биохимийн үйлдвэр (Үндсэн цех)          | 1 м.кв |         | 971.69  | 844.95  |         |        |
| 14                                       | Халаалтын тогооны барилга               | 1 м.кв | 1379.04 | 1253.67 | 1065.62 | 959.06  | 880.00 |
| Дөрөв.Хөдөө аж ахуйн барилга, байгууламж |   |        |         |         |         |         |        |
| 1  | Сүүний механиксан ферм                  | 1 үнээ | 2338.35 |         | 1987.60 | 1753.76 |        |
|  | Энгийн ферм                             | 1 үнээ |         |         | 580.0   | 490.0   |        |
| 2  | Гахайн байр                             | 1 мэгж | 822.68  |         |         |         |        |
|  |   | 1 м.кв | 918.31  |         | 780.56  | 688.73  |        |
| 3  | Тэжээлийн агуулах                       | 1 м.кв | 664.17  |         | 564.54  | 498.13  |        |
|  |   | 1 тн   |         | 745.39  |         |         |        |
| 4  | Ногооны агуулах                         | 1 м.кв |         | 1054.55 | 843.64  | 790.91  |        |
|  |   | 1 тн   |         | 943.20  |         |         |        |
| 5  | Зоорь                                   | 1м.куб |         | 680.50  | 544.40  | 510.38  |        |

| Тав. Тусгай зориулалтын зарим барилга, байгууламж |   |                 |   |
|---|---|-----------------|---|
|   | Нэр төрөл   | Хүчин чадал     | Нийт хүч чадлын жишиг үнэлгээ, сая төг    |
| 1   | Цементийн агуулах                                 | 100 тн          | 27.00                                     |
|   | Цементийн агуулах                                 | 1000 тн         | 85.00                                     |
| 2   | Зуурмагийн үзэл /тоног төхөөрөмжийн хамт/         | 1000 өдөр/м.куб | 400.00                                    |
|   | Зуурмагийн үзэл /тоног төхөөрөмжийн хамт/         | 3000 өдөр/м.куб | 1840.0                                    |
|   | Нэр төрөл   | Хүчин чадал     | Нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ /мян.төг/ |
| 3   | Үр тариа хадгалах сав /метал силос/ 180тн -300тн  | 1м.куб          | 140.0                                     |
|   | Үр тариа хадгалах сав /метал силос/ 300тн-1000 тн | 1м.куб          | 120.0                                     |
| 4   | Резервуар   | 1м.куб          | 249.2                                     |

Барилга, хот байгуулалтын сайдын  
2018 оны 2 дугаар сарын 2 ны өдрийн  
203 дугаар тушаалын 3-р хэсрэлт



**ГАДНА ЗАМ ТАЛБАЙ, БУСАД ЖИЖИГ БАРИЛГА, ТОХИЖИЛТЫН АЖЛЫН  
НЭГЖ ХУЧИН ЧАДЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ**

| д.д | Нэр төрөл           | Хийцийн төрөл   | Хучин чадлын хэмжих нэгж | Улаанбаатарт мян.төг |
|-----|---------------------|---|--------------------------|----------------------|
| 1   | Жижиг барилгууд     | Банзан буюу бамбай барилга  | 1 м.кв                   | 273.36               |
|     |                     | Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сандвичин барилга/ | 1 м.кв                   | 691.60               |
|     |                     | Дүнзэн барилга  | 1 м.кв                   | 409.36               |
|     |                     | Шургааган байшин /хөрөнгийн үнэлгээнд/                                  | 1 м.кв                   | 206.02               |
|     |                     | Чулуун байшин   | 1 м.кв                   | 205.02               |
|     |                     | Мод, тоосго, блокон холимог ханатай барилга                             | 1 м.кв                   | 420.00               |
| 2   | Хашаа               | Модон хашаа   | 1 м.кв                   | 24.92                |
|     |                     | Угсармал төмөр бетон хашаа  | 1 м.кв                   | 45.50                |
|     |                     | Төмөр сараалжин хашаа   | 1 м.ка                   | 21.08                |
| 4   | Явган зам           | Шигтгэмэл хавтан явган зам  | 1 м.кв                   | 48.50                |
|     |                     | Цутгамал бетон явган зам  | 1 м.кв                   | 32.30                |
| 5   | Авто машины зогсоол | Автомашины бетонон хучилттай зогсоол                                    | 1 м.кв                   | 68.00                |
|     |                     | Автомашины асфальтобетон хучилттай зогсоол                              | 1 м.кв                   | 62.30                |
| 6   | Хайс, хашлага       | Төмөр сараалжин (Бетонон суурьтай)                                      | 1 м.кв                   | 40.80                |
|     |                     | Модон сараалжин хайс  | 1 м.кв                   | 6.80                 |
| 7   | Жижиг агуулах       | Бетон агуулах   | 1 м.кв                   | 255.00               |
|     |                     | Модон агуулах   | 1 м.кв                   | 119.00               |
|     |                     | Чулуун агуулах  | 1 м.кв                   | 119.00               |
| 8   | Тохижилт            | Зүлэгжүүлсэн талбай   | 1 м.кв                   | 11.70                |
|     |                     | Шилмүүст мод  | 1 суулгац                | 38.30                |
|     |                     | Навчит мод  | 1 суулгац                | 7.30                 |
|     |                     | Бут, сөөг   | 1 суулгац                | 5.00                 |
|     |                     | Биеийн тамирын талбай   | 1 м.кв                   | 34.00                |
|     |                     | Сагсны иж бүрэн шит   | 1 иж бүрдэл              | 680.00               |
| 9   | Үерийн далан        | Тоглоомны талбай  | 1 м.кв                   | 85.00                |
|     |                     | Шорсон  | 1 у.м                    | 154.40               |
| 10  | Гэрэлтүүлэгийн шон  | Бетон хучилттай   | 1 у.м                    | 194.60               |
|     |                     | Гэрэлтүүлгийн метал шон   | 1 ширхэг                 | 450.00               |

|    |  |                           |          |         |
|----|--|---------------------------|----------|---------|
|    |  | Гэрэлтүүлгийн бетон шон   | 1 ширхэг | 68.00   |
| 11 | Хүйтэн гарааж  | Угсармал хавтан (1 машин) | м2       | 544.00  |
|    |  | Тоосгон (1 машин)         | м2       | 629.00  |
| 12 | Шатахуун түгээх станцын барилга (Түгээгч, үйлчилгээний байр) |                           | м2       | 1096.11 |

Барилга, хот байгуулалтын сайдын  
2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн  
203 дугаар тушаалын 4-р хэвсрэлт



**ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, ТҮҮНИЙ БАРИЛГА-БАЙГУУЛАМЖИЙН  
НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ**

**1. Гадна дулааны сүлжээ, барилга байгууламж**

| Сувгийн төрөл   | Сувгийн хэмжээ | Хоолойн материал | Хоолойн хэмжээ  | 100м-ийн жишиг үнэлгээ /сая. төг/    |
|---|----------------|------------------|---|--------------------------------------|
| Тоосго  | 800x385        | Ган              | 2Ф89, Ф57   | 74.94                                |
|   | 1200x460       |                  | 2Ф89, 2Ф57, Ф32   | 109.14                               |
|   | 1600x460       |                  | 3Ф108, Ф89, Ф57   | 113.07                               |
|   | 1800x610       |                  | 3Ф108, Ф89, Ф57   | 142.55                               |
| цутгамал  | 800x385        | Ган              | 2Ф89, Ф32   | 84.90                                |
|   | 1200x460       |                  | 2Ф89, 2Ф57, Ф32   | 119.78                               |
|   | 1600x460       |                  | 3Ф108, Ф89, Ф57   | 122.64                               |
|   | 1800x610       |                  | 3Ф108, Ф89, Ф57   | 145.55                               |
| угсармал  | 900x450        | Ган              | 2Ф89, Ф32   | 64.45                                |
|   | 1200x600       |                  | 2Ф89, 2Ф57, Ф32   | 119.44                               |
|   | 1500x800       |                  | 2Ф219, Ф159   | 204.87                               |
|   | 2100x600       |                  | 2Ф325, Ф219   | 268.89                               |
|   | 2100x600       |                  | 2Ф377   | 220.51                               |
|   | 2100x600       |                  | 2Ф630   | 246.58                               |
| Нэвтрэх хонгил /2.4-ийн өргөнтэй, 3м-ийн өндөртэй хонгил/   |                |                  | Цутгамал т/б нэвтрэх сувагт байрлуулсан Ф40-250 хүртэлх дулааны, Ф50-150мм хүртэлх цэвэр усны, холбоо, цахилгаан, автомат дохиолол бүхий хонгилын иж бүрэн систем | 676.69                               |
| Дулаан дамжуулах төвийн 1 иж бүрдлийн төсөвт өртөг /ДДТ иж бүрэн/   |                |                  | Хүчин чадал   | Иж бүрдлийн жишиг үнэлгээ /сая. төг/ |
| УДДТөвийн барилга /Халаалт, салхивч, дулаан механик, цэвэр бохир ус, гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж бүхий/    |                |                  | 7гкал/цаг   | 517.19                               |
| УДДТөвийн барилга/Халаалт, салхивч, дулаан механик, цэвэр ус, бохир ус, гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж бүхий/ |                |                  | 1-5 гкал/цаг  | 287.17                               |

2. Ариутгах татуургын сүлжээ, барилга байгууламж

| Бохирын шугам                           | Хоолойн төрөл                        | Хоолойн хэмжээ   | 100м-ийн жишиг үнэлгээ /сая. төг/ |
|---|--------------------------------------|--|-----------------------------------|
| Хуванцар                                | Полиэтилен хуниаст гадаргуутай /SN8/ | Ф100   | 16.14                             |
|   |                                      | Ф150   | 29.99                             |
|   |                                      | Ф300   | 31.77                             |
|   |                                      | Ф800   | 41.71                             |
| Ширэм                                   | Зөөлөн ширэм /Ductile iron/          | Ф100   | 22.11                             |
|   |                                      | Ф150   | 24.64                             |
|   |                                      | Ф300   | 31.99                             |
|   |                                      | Ф800   | 80.03                             |
| Төмөр бетон                             | Бурзантай төмөр бетон /6м урттай/    | Ф300   | 19.02                             |
|   |                                      | Ф450   | 23.94                             |
|   |                                      | Ф500   | 33.16                             |
|   |                                      | Ф800   | 41.07                             |
| Бохирын цооног                          | Зориулалт                            | Хүчин чадал  | 1 м3-ийн жишиг үнэлгээ /сая.төг/  |
| Цутгамал төмөр бетон                    | Ахуйн /Үйлдвэрийн/                   | (30м3-40м3)  | 1.57                              |
| Цэвэрлэх байгууламж /ахуйн хэрэглээний/ |                                      | Хүчин чадал  | 1 м3-ийн жишиг үнэлгээ /сая.төг/  |
|   |                                      | Барилга, халаалт салхивч, цэвэр бохир ус, гэрэлтүүлэг, элсний талбай, лагийн талбай, биоцөөрөм, эрлифт, жигдрүүлэх сан, бусад шугам сүлжээ | 11.95                             |
| Цэвэрлэх байгууламж /үйлдвэрийн/        |                                      | Сараалжийн барилга, бохирын шугам, халаалт салхивч, технологийн хэсэг, цөөрмийн далан, биоцөөрмүүд   | 8.2                               |
| Бохир усны насос станц                  |                                      | Цутгамал төмөр бетон суурь бүхий сандвичэн барилга /халаалт, цэвэр, бохир ус, гэрэлтүүлэг, технологийн хэсгийн хамт/                       | 1.79                              |

3. Ус хангамжийн сүлжээ, барилга байгууламж

| № | Цэвэр усны шугам | Хоолойн төрөл        | Хоолойн хэмжээ   | 100м-ийн жишиг үнэлгээ /сая.төг/ |
|---|------------------|----------------------|--|----------------------------------|
| 1 | Хуванцар         | HDPE PE100 SDR11     | Ф110   | 19.48                            |
|   |                  |                      | Ф200   | 23.50                            |
|   |                  |                      | Ф250   | 24.33                            |
|   |                  |                      | Ф355   | 39.36                            |
|   |                  |                      | Ф400   | 48.09                            |
|   |                  |                      | Ф450   | 53.64                            |
|   |                  |                      | Ф500   | 78.67                            |
|   |                  |                      | Ф630   | 99.93                            |
| 2 | Ган              | Шулуун оёдолтой      | Ф80  | 15.58                            |
|   |                  |                      | Ф150   | 16.35                            |
|   |                  |                      | Ф325   | 46.79                            |
|   |                  |                      | Ф600   | 62.66                            |
|   |                  |                      | Ф800   | 119.35                           |
| 3 | Усан сан         | Цутгамал төмөр бетон | Хүчин чадал  | 1 м3-ийн жишиг үнэлгээ /сая.төг/ |
|   |                  |                      | Усан сан, халаалтын байр, манаачийн бутка, халаалт, салхивч, гэрэлтүүлэг, технологийн хэсэг /500-1500м3/ | 0.481                            |

#### 4. Холбооны шугам сүлжээ

|   | Нэр төрөл  | Хүчин чадал                            | 100 м-ийн жишиг өртөг /сая. төг/ |
|---|--|--|----------------------------------|
| 1 | Гол сувагчлал, угсармал төмөр бетон худаг /ф-110 мм/   | (2+0) сувагчлалтай, L4T төрлийн /жжиг/ | 9.64                             |
|   |  | (4+0) сувагчлалтай, L5T төрлийн /дунд/ | 13.11                            |
|   |  | (6+0) сувагчлалтай, M1 төрлийн /гом/   | 17.54                            |
|   |  | (9+0) сувагчлалтай, M1 төрлийн /гом/   | 22.24                            |
|   | Салбар сувагчлал /ф-63 мм/, угсармал төмөр бетон худаг | (0+2) сувагчлалтай, L4T төрлийн /жжиг/ | 5.18                             |
|   |  | (0+4) сувагчлалтай, L5T төрлийн /дунд/ | 8.10                             |
| 2 | Сувагчлалаар кабель суурилуулах                        | Шилэн кабель FO-8                      | 0.41                             |
|   |  | Шилэн кабель FO-12                     | 0.43                             |
|   |  | Шилэн кабель FO-24                     | 0.53                             |
|   |  | Шилэн кабель FO-48                     | 0.86                             |
|   |  | Шилэн кабель FO-96                     | 1.07                             |
|   |  | Шилэн кабель FO-144                    | 1.38                             |
|   |  | Физик кабель 10 хос                    | 0.58                             |
|   |  | Физик кабель 20 хос                    | 0.73                             |
|   |  | Физик кабель 30 хос                    | 0.90                             |
|   |  | Физик кабель 50 хос                    | 1.21                             |
|   |  | Физик кабель 100 хос                   | 1.98                             |
|   |  | Физик кабель 200 хос                   | 3.39                             |
| 3 | Агаарын баганат шугам байгуулж, кабель татах           | Шилэн кабель FO-8                      | 0.98                             |
|   |  | Шилэн кабель FO-12                     | 1.00                             |

|   |                           |                      |                                       |
|---|---------------------------|----------------------|---------------------------------------|
|   |                           | Шилэн кабель FO-24   | 1.07                                  |
|   |                           | Шилэн кабель FO-48   | 1.22                                  |
|   |                           | Шилэн кабель FO-96   | 1.49                                  |
|   |                           | Физик кабель 10 хос  | 1.04                                  |
|   |                           | Физик кабель 20 хос  | 1.14                                  |
|   |                           | Физик кабель 30 хос  | 1.23                                  |
|   |                           | Физик кабель 50 хос  | 1.38                                  |
|   |                           | Физик кабель 100 хос | 1.75                                  |
| 4 | Газрын кабель суурилуулах | Шилэн кабель FO-12   | 2.12                                  |
|   |                           | Шилэн кабель FO-24   | 2.18                                  |
|   |                           | Шилэн кабель FO-48   | 2.33                                  |
|   |                           | Шилэн кабель FO-96   | 2.58                                  |
|   |                           | Физик кабель 50 хос  | 2.67                                  |
|   |                           | Физик кабель 100 хос | 2.89                                  |
|   |                           | Физик кабель 200 хос | 3.61                                  |
| 5 | Нэр төрөл                 | Хүчин чадал          | 1 иж бүрдлийн жишиг үнэлгээ /сая.төг/ |
|   | Хуваарилах шүүгээ         | Физик кабелийн       | 2.814                                 |
|   |                           | Шилэн кабелийн       | 4.56                                  |

5. Цахилгааны шугам сүлжээ, барилга байгууламж

| Цахилгааны барилга байгууламж, дамжуулах шугамын нэр | Төрөл                                   | Хүчин чадал                        | 100м-ийн жишиг үнэлгээ /сая.төг/      |
|--|---|------------------------------------|---------------------------------------|
| А. Цахилгаан дамжуулах шугам                         | кабель /Хөнгөнцагаан голтой/            | 0.4 кВ 3х35+1х16 мм <sup>2</sup>   | 3.93                                  |
|  |   | 0.4 кВ 3х70+1х35 мм <sup>2</sup>   | 4.47                                  |
|  |   | 0.4 кВ 3х95+1х50 мм <sup>2</sup>   | 5.24                                  |
|  |   | 0.4 кВ 3х185+1х95 мм <sup>2</sup>  | 6.85                                  |
|  |   | 0.4 кВ 3х240+1х120 мм <sup>2</sup> | 7.19                                  |
|  |   | 10 кВ 3х35 мм <sup>2</sup>         | 4.83                                  |
|  |   | 10 кВ 3х70 мм <sup>2</sup>         | 5.94                                  |
|  |   | 10 кВ 3х95 мм <sup>2</sup>         | 6.30                                  |
|  |   | 10 кВ 3х185 мм <sup>2</sup>        | 7.48                                  |
|  |   | 10 кВ 3х240 мм <sup>2</sup>        | 7.85                                  |
|  | Агаарын шугам                           | 0.4 кВ СИП утастай                 | 3.11                                  |
|  |   | 10 кВ АС утастай                   | 2.75                                  |
|  |   | 15 кВ АС утастай                   | 2.72                                  |
|  |   | 35 кВ АС утастай                   | 4.37                                  |
| Б. Цахилгааны барилга байгууламж                     | Төрөл                                   | Хүчин чадал                        | 1 иж бүрдлийн жишиг үнэлгээ /сая.төг/ |
|  |   |                                    |                                       |
|  | Агаарын дэд өртөө                       | 10 /0.4 кВ, 100кВа                 | 22.7                                  |
|  |   | 10 /0.4 кВ, 160кВа                 | 24.7                                  |
|  |   | 10/0.4 кВ, 250 кВа                 | 26.6                                  |
|  |   | 10/0.4 кВ, 400 кВа                 | 31.4                                  |
|  |   | 35/0.4кВ, 400 кВа                  | 98.6                                  |
|  | Хаалттай дэд өртөө /Ачаалал таслагчтай/ | 10 /0.4 кВ, 250кВа                 | 236.9                                 |
|  |   | 10 /0.4 кВ, 400кВа                 | 244.6                                 |
|  |   | 10/0.4 кВ, 630 кВа                 | 254.7                                 |
|  |   | 10/0.4 кВ, 800 кВа                 | 231.6                                 |
|  |   | 10/0.4кВ, 1000 кВа                 | 292.6                                 |
|  | Хаалттай дэд өртөө /Вакуум таслууртай/  | 10 /0.4 кВ, 250кВа                 | 339.9                                 |
|  |   | 10 /0.4 кВ, 400кВа                 | 347.7                                 |
|  |   | 10/0.4 кВ, 630 кВа                 | 362.7                                 |
|  |   | 10/0.4 кВ, 800 кВа                 | 328.8                                 |
|  |   | 10/0.4кВ, 1000 кВа                 | 394.2                                 |
|  | Иж бүрэн дэд өртөө /КТПН/               | 10 /0.4 кВ, 160кВа                 | 29.3                                  |
|  |   | 10 /0.4 кВ, 400кВа                 | 38.4                                  |
|  |   | 10/0.4 кВ, 630 кВа                 | 43.4                                  |

|                                     |             |        |
|-------------------------------------|-------------|--------|
| Хаалттай<br>хувиарлах<br>байгууламж | 16 ячейттай | 561.09 |
|                                     | 20 ячейттай | 780.07 |